

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№4 (1)

2021.07.19

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН БАРИВ



Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Баделхан, Х.Булгантуяа нар 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар өргөн барив. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2011 оны аравдугаар сарын 6-ны өдөр 7 бүлэг, 24 зүйл, 188 заалттайгаар баталсан бөгөөд хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 80 заалт нь хэрэгжиж байгаа, үлдсэн

108 заалтын 40 гаруй хувь нь хэрэгжилт хангалтгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарчээ. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн зарим чиг үүрэг, бүрэн эрхийн асуудлыг нарийвчлах; хот, суурин газар дахь гэр хорооллын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй өрхүүд, хөдөөгийн хүн амын ариун цэврийн байгууламжийн ашиглалт, түүнчлэн лагийг зөөвөрлөх, байгальд эргүүлэн нийлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах; эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламжийг мэргэжлийн байгууллагад хариуцуулах; цэвэрлэх байгууламжаас гарсан лагийг боловсруулах, үйлдвэрийн технологийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглээнээс гарч буй бохирдол ихтэй усыг урьдчилан цэвэрлэсний дараа ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлэх харилцааг боловсронгуй болгох, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагыг үндэслэн төслийг боловсруулсан байна.

[Эх сурвалж: gogo.mn](http://gogo.mn)

ГАЗРЫН ДООРХ УСНЫ ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ТЭНХИМИЙГ МОНГОЛ СУДЛААЧ УДИРДАНА

Их, дээд сургуулиуд хооронд мэдлэг солилцох олон улсын сүлжээ бий болгох зорилгоор ЮНЕСКО 1992 оноос “Юнитвин” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ. Ингэснээр тус байгууллагын гишүүн орнууд судалгаа шинжилгээний тэнхим байгуулан ажиллах боломж бүрдсэн юм. Одоогоор тус хөтөлбөрийн хүрээнд 134 оронд 834 тэнхим байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд манай улс энэ жишгээр Японы улсын Цүбакигийн их сургуультай хамтран Газрын доорх усны тогтвортой менежментийн тэнхимийг ШУА-ийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн дэргэд 2007 онд байгуулсан. Тус тэнхимийг байгуулсан цагаас хойш Цүбакигийн их сургуулийн профессор Танака Тадаши, Маки Цүжимарү нар Монгол Улсын зөвлөх инженер, доктор Л.Жанчивдоржтой хамтран удирдаж ирсэн байна. Харин энэ жилээс тус тэнхимийн удирдлагаар усны нөөц, ашиглалтын чиглэлээр мэргэшсэн, ШУА-ийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн Усны нөөц, ус ашиглалтын салбарын дарга, усны барилга байгууламжийн инженер, доктор С.Чинзориг томилогдон ажиллахаар болжээ.

[Эх сурвалж: Unuudur.mn](http://Unuudur.mn)

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ 15 ТӨРЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ГААЛЬ БОЛОН НӨАТ-ААС, 59 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ААНОАТ-ААС ЧӨЛӨӨЛСӨН БАЙДАГ

Монгол Улсын Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй халаагуур, дотоод орчны агаарыг цэвэршүүлэх 15 төрлийн тоног төхөөрөмжийг Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Мөн агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн нийт 59 тоног төхөөрөмжийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлж ногоон худалдан авалтыг бодлогоор дэмжин ажиллаж байна. Энэхүү жагсаалтад ус шүүх, цэвэрлэх төхөөрөмж, дуслын усалгааны гуурс, хоолой, шланг, усан болон усан цэнэгт цахилгаан станцын тоног төхөөрөмжүүд зэрэг багтдаг байна. Түүнчлэн Байгалийн нөөц, эрчим хүчийг хэмнэх, хог хаягдал болон дулаан алдагдлыг багасгах дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн 12 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж “Ногоон гэрчилгээ”, мөнгөн урамшуулал олгосон. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд материалаа ирүүлэх нь нээлттэй аж.

[Эх сурвалж: БОАЖА](http://BOAJA)

ТОВЧХОН



УСУГ Дусалхүү подкастынхаа ээлжит дугаарыг [“Бага оврын цэвэрлэх байгууламж болон цэвэршүүлсэн усаа эргүүлэн ашиглах заавар”](#) болон [“Санал хүсэлт, гомдол барагдуулах үйл ажиллагаа”](#) сэдвээр хүргэж байна. Подкастын зочноор УСУГ-ын ХҮА-ны Бохирдуулагч үйлдвэрийн хяналтын инженер Т. Билгүүн, тус албаны Борлуулалт, мэдээлэл лавлагааны инженер Д. Отгонжаргал нар оролцож дээрх сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ [Эх сурвалж: УСУГ](#)

Нийслэлийн дулааны шугам сүлжээний засварын ажилтай холбогдуулан энэ сарын 19 -30-нд халуун ус хязгаарлах байршлуудыг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК мэдээлэв. Эх сурвалжийн мэдээлснээр, 7 дугаар сарын 19-нөөс 7 дугаар сарын 30-ны хооронд Жаргалан хотхон, МХАУТанхим, Солонгос элчин, Оддын хотхон, Энканто таун, Маршал таун, Ривер гарден хотхон, Баян Монгол хороолол, Шинэ Монгол сургууль орчим, Ногоон төгөл хотхон, 13-р хороолол УДДТ-26, 27, Нарантуул зах, Ахмадын хороолол, Сүнжин гранд зочид буудал, Баянзүрх дүүрэг, Госпитал, БХЯам, 16-р хороолол, Амгалан орчмын хэрэглэгчид, Отгонтэнгэр дээд сургууль, Монгол кино нэгтгэл, ШУА-ийн хүрээлэн орчмын хэрэглэгчдийн халуун усыг 3–11 хоног хязгаарлах юм байна. [Эх сурвалж: МОНЦАМЭ](#)